



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 18 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 1а/3161 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Соёл, Урлагийн Их Сургуульд өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр, 1,200,000,000.00 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөгт багтаан хавсралтад заасан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Соёл, Урлагийн Их Сургуулийн захирал Э.Сонинтогос нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Оюутны дотуур байрны өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ВҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001605

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
...124... дугаар тогтоолын хавсралт



Соёл, Урлагийн Их Сургуульд олж авах
үндсэн хөрөнгө

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг буюу худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Оюутны дотуур байрны өргөтгөлийн барилга угсралтын ажил	ш	1	1,200,000,000.00
Нийт дүн			1	1,200,000,000.00
				(нэг тэрбум хоёр зуун сая)